

**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ**

20. Коны 28 сарын 31 өдөр      Дугаар 07

*Хэсэгч... Оюу*

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 8.1, 8.2 дахь заалтын дагуу нэг талаас ..... *Нийтийн* аймаг /хот/ -ын ..... *Нийтийн* сум /дүүрэг/ -ийн Засаг дарга ..... *Оюунтэж* овогтой ..... *Дэлхийн* цаашид "Засаг дарга" гэх/ нөгөө талаас бичил уурхайн ..... *СХР* ..... нэртэй бүртгэгдээгүй нөхөрлөл /цаашид "нөхөрлөл" гэх/-ийг төпөөлж нөхөрлөлийн ахлагч ..... *СХР* ..... овогтой ..... *Нийтийн* бид нар харилцан тохиролцож энэхүү гэрээ /Цаашид" гэрээ" гэх/-ыг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Нөхөрлөл нь ..... *Нийтийн* сум /дүүрэг/ -ийн ..... *Хэсэгч... Оюу* ..... гектар талбайд нэг жилийн хугацаагаар ..... *176 га* ..... олборлох үйл ажиллагаа эрхлэнэ /ашигт малтмалын төрөл/
- 1.2 бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум /дүүрэг/ -н Засаг дарга, нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг**

2.1 Сум, дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1.1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3-т заасан үүрэг хүлээнэ.

2.1.2. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээг тогтоож, талбайн байршлын зургийг гэрээнд хавсаргах.

2.1.3. нөхөрлөлийн гишүүдийн амьдрах суурьшлийн бус болон хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх


2.1.4. Олборлолт явуулсан талбайг буцаан хүлээлгэж өгөхийн өмнө хийх нөхөн сэргээлтийн зааврыг нөхөрлөлд танилцуулж ойлголцсон байх.

2.1.5. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээтэй уялдуулан олборлолт явуулсан талбайд хийх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, хугацааг нөхөрлөлтэй харилцан тохиролцож зохих хөрөнгийг төвлөрүүлэх

2.1.6. "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм" –ийг дагаж мөрдөж байгаа эсэх, ажлын байрны заavarчлага өгөх үүргээ нөхөрлөлийн ахлагч биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих

2.1.7. Гишүүдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барилд сургах ажлыг мэргэжлийн байгууллагын тусlamжтайгаар зохион байгуулах

2.1.8. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдах үйл ажиллагаанд хяналт тавих, олборлолтын мэдээ хөтөлжийнтээл сүйжүүлэх Засаг даргын тамын газар



2.1.9. Нөхөрлөлийн гишүүдэд эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах

2.1.10. Нөхөрлөлөөс талбайг буцааж хүлээлгэж өгөхийн өмнө хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь байгаль орчны хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулан, комисс томилж хүлээн авах.

2.1.11. Нөхөрлөлд ашигт малтмал олборлох талбай дахин олгох асуудлыг шийдвэрлэх

2.1.12. нөхөрлөлд гэрээгээр олгосон талбай дээр нөхөрлөлийн гишүүн бус этгээд ажиллаж буй эсэхэд хяналт тавих

2.1.13. нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах

2.2 Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3-т заасан эрх эзэлнэ.

2.2.2. Нөхөрлөлд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

2.2.3. Нөхөрлөлийн ахлагчид үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлийг шалгах

2.2.4. Гэрээний үүргээ биелүүлэхгүй, ашигласан талбайн нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцлах

2.2.5. Хүн, мал, байгаль орчинд харш үйл ажиллагааг зогсоох.

### Гурав. Нөхөрлөлийн эрх, үүрэг

3.1. Нөхөрлөл дараах үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Нөхөрлөлийн гишүүдийг тогтоосон бүсэд суурьшуулах

3.1.2. Нөхөрлөл нь гэрээнд заасан талбайн хил, хязгаарын дотор үйл ажиллагаа явуулах

3.1.3. Байгаль орчныг хамгаалах, гол ус, булаг шанд, уст цэгүүдийг бохирдуулахгүйгээр зүй зохистой хэрэглэх.

3.1.4. Орчны тохижилт хийх, хог хаягдлын цэгийг байгуулах

3.1.5. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх, осол аваараас урьдчилан сэргийлэх арга техникт суралцах

3.1.6. Ашигт малтмалыг баяжуулах, ялгаж ангилах үйл ажиллагааг тогтоосон зориулалтын цэг талбайд гүйцэтгэх

3.1.7. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож сум, дүүргийн Засаг даргын тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах *ЖИЛДЭХ... САХАРЫН... ТӨГРӨГИЙГ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ДУНДЫН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ* төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх

3.1.8. Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэнд зарцуулах

3.1.9. Талбайг хүлээлгэн өгөхийн өмнө нөхөн сэргээлт хийж сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн Засаг даргын томилсон комиссст хүлээлгэн өгөх

3.1.10. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдана.

3.1.11. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд гишүүдийг идэвхитэй оролцуулах

19.04.09  
Зарч

3.1.12. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бичил уурхай эрхлэгч иргэний орлогын албан татвар төлөх

3.1.13. Хууль ёс нийгмийн хэв журмыг зөрчсөн аливаа үйлдэлтэй хамт олноороо тэмцдэг байх

3.1.14. Үйл ажиллагаанд хими хорт болон аюултай бодис ашиглахгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахгүй байх

3.1.15. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайд зөвхөн нөхөрлөлийн гишүүнийг ажилуулах

3.1.16. Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 500см<sup>3</sup> -ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглахгүй байх.

3.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Нөхөрлөлд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах

3.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бичил уурхайн бүтэц, зохион байгуулалт, технологи сайжруулахтай холбогдсон санал, санаачлага гаргах

3.2.3. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгөх, дахин ашигт малтмал олборлох гэрээ байгуулах өргөдөл гаргах.

#### Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

4.1. Гэрээнд оролцогч талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу олборлолт явуулж байгаа нөхөрлөлийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, хүн майд ноцтой хохирол учирвал нөхөрлөл уг хохирлыг барагдуулах үүрэг хүлээх ба Засаг дарга тухайн нөхөрлөлөөс уг хохирлыг барагдуулахыг шаардах үүрэгтэй.

#### Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

#### Зургаа. Гэрээний үйлчлэх хугацаа

6.1. Энэхүү гэрээ .../.../...-оны .../.../...-арын .../.../...-өдрөөс .../.../...-оны .../.../...-арын .../.../...-өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.4. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

6.5. Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

Сум/дүүрэг/-ийн Засаг дарга  
Хаяг: .....  
Утасны дугаар: 990293381

Чадвагч нөхөрлөлийн ахлагч  
Монголын .../.../.../.../.../.../...  
Хаяг: .../.../.../.../.../.../...  
Утасны дугаар: 98241206

12.04.09  
.../.../...